



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1146

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулж,
байгууллагын эд хөрөнгийн
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, материалын тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга	М.Цогзолмаа	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд	Э.Мөнх-Эрдэнэ	Спорт, нийтийн биеийн тамирын ахлах мэргэжилтэн
	У.Буян-Орших	Архив, албан хэргийн эрхлэгч
Нарийн бичиг	Б.Оюунтуяа	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

2.Тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 27-ний дотор байгууллагын даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг тооллогын комиссын дарга (М.Цогзолмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны
өдрийн 1146 дугаар тушаалын хавсралт



Тооллого явуулах хуваарь

д/д	Тооллого хийх газрууд	Хуваарьт өдрүүд	Тайлбар
1.	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өрөө тасалгаануудын эд хогшил техник хэрэгслийг тоолох;	2025.06.23-25-нд	Тооллогын комиссын гишүүд нийтээр оролцоно.
2.	Тооллогын дүнг нэгтгэх, холбогдох байгууллагад хүргүүлэх ажиллах.	2025.06.27-нд	Тооллогын комиссын гишүүд нийтээр оролцоно.